



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 062

Улаанбаатар хот

Г Орон нутгийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Эрүүл мэндийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон, нийт 4,208,444,580.00 (дөрвөн тэрбум хоёр зуун найман сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга таван зуун ная) төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн цогцолбор барилга байгууламжийг хавсралтад заасны дагуу Баянхонгор, Хэнтий аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг тур орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Баянхонгор, Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргaa, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, Сумын Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн хөрөнгөд бүртгэх, асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.



ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
123006808
2-r huraldaan.docx

Төрийн Өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 11 дугаар сарын 11-ний өдрийн
дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХУУЖИЛТ (ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦ)-ЭР ВАРЬСАН
ОРОН НУТГИЙН ӨМЧИД БУРТГЭХ ХӨРӨНГО (БАРИЛГА БАЙГУУЛАМЖ)-ИЙН ЖАГСАЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дун (төгрөг)	Улсын комиссын акт		Орон нутгийн өмчид буртгэх аймаг, Ашиглагч байгууллага
				Огноо	Дугаар	
1	Эрүүл мэндийн төвийн барилга (Хэентий аймаг, Батширээт сум, Эмнэлгийн өргөтгөлийн барилга, өөрийн эзэмшилийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, дунд антилалын, зооруугүй, 2 давхар, 10 ортой, тэнхлэгээрээ 22.0м*12.5м, 6.05м*2.5м хүзүүвчтэй барилга	1,598,844,580.00	2023.11.07	68/2023	Хэнтий аймаг, Батширээт сум Эрүүл мэндийн төв
3	Эрүүл мэндийн төвийн барилга (Баянхонгор аймаг, Эрдэнэцогт сум, Эрүүл мэндийн төвийн эзэмшилийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, дунд төлөвшүүлтэй ангилалын, зооруугүй, 2 давхар, 15 ортой, тэнхлэгээрээ 46.4м*16.8м хэмжээтэй барилга, эмчийн байр 2 автомашини гражийн барилга тэнхлэгээрээ 15.0м*8.0м 2 1 давхар, зоорьгүй,	2,609,600,000.00	2023.12.14	2023/44	(Баянхонгор аймаг, Эрдэнэцогт сум, Эрүүл мэндийн төв
НИЙТ ДҮН				4,208,444,580.00		(Дөрвөн тэрбум хоёр зуун найман сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга таван зуун наян төгрөг)